



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 22 өдөр

Дугаар А/295

Чөнгис хот

Хуулийн хэрэгжилтийг
хангаж ажиллах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ын "а", Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1, 70.2, 70.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн санал авах ажиллагааг 6 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулахтай холбогдуулан тус өдөр аймгийн хэмжээнд согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдах, соёл урлаг, үзвэр, спортын зэрэг олныг хамарсан аливаа арга хэмжээ зохион байгуулах, гадаа болон битүү талбайд үйл ажиллагаа явуулдаг худалдаа, үйлчилгээний төв ажиллахыг тус тус хориглосугай.

2. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуй нэгж, байгууллагыг мэдээллээр хангаж, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар /хурандаа Б.Батсайхан/, сумын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА